



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Консерваторийн 2019 оны байдлаарх үндсэн хөрөнгийн хөдлөл, хөдөлгөөн, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, эзэмшил газрын эрх зүйн үндэслэл, байр талбайн түрээсийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч нийт 234.0 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Консерваторийн 2019 оны үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Монгол Улсын Консерваторийн захирал Ц.Пүрэвхүү нарт дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1.Монгол Улсын Консерваторийн төрийн эзэмшлийн газарт байршиж байгаа сурталчилгааны самбарыг буулгаж, газар чөлөөлүүлэн зориулалтын дагуу ашиглах;

2.2.Байшин барилга, машин техникийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох сэргээн босголтын зардлыг тусгасан тухайн хөрөнгийн хувийн хэргийн баяжуулалтыг чанаржуулж, Барилга, хот байгуулалтын сайдын “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай” 2016 оны 180 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах;

2.3.Улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн 234.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг холбогдох журмын дагуу төсөвт төвлөрүүлэх, цаашид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай зааврыг мөрдөж ажиллах;

2.4.Монгол Улсын Консерваторийн төрийн эзэмшлийн газарт 2003 онд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр баригдсан 610.0 м.кв талбай бүхий орон сууцны барилгын төрийн эзэмшлийн газрын асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, цаашид “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах;

2.5.Монгол Улсын Консерваторийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 1962 онд баригдаж ашиглалтад орсон, модон хучилт бүхий 4,014.66 м.кв хэмжээтэй, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй талаар Улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гарсан, хичээлийн 1-р байрны барилгын асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах;

132001360

2.6.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА





Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2021 оны 09 дугаар сарын 05-ний өдрийн  
10 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төсөвт дутуу төвлөрүүлсэн түрээсийн төлбөр	Захирал Ц.Пүрэвхүү Ерөнхий ня-бо Д.Болормаа	234.0	Мөрдэж буй журмын дагуу дутуу төвлөрүүлсэн түрээсийн төлбөрийг төсөвт төлөх
	<b>Дүн</b>		<b>234.0</b>	
1	Түрээсийн гэрээгүй байршиж байгаа зар сурталчилгааны самбар	Захирал Ц.Пүрэвхүү Ерөнхий ня-бо Д.Болормаа		Зар сурталчилгааны самбарыг буулгах
2	Сургуульд хандивласан гэх боловч шийдвэр гаралгүй байгаа циркийн асар, зориулалтын чиргүүл	Захирал Ц.Пүрэвхүү Ерөнхий ня-бо Д.Болормаа		Хандивын асуудлыг тодорхой болгож, орлогод авах асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх
3	Сургуулийн эзэмшил газар 2013 онд баригдсан орон сууцны барилга, зам талбайн газар	Захирал Ц.Пүрэвхүү Ерөнхий ня-бо Д.Болормаа		Асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх